



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: [stategreathural@parliament.mn](mailto:stategreathural@parliament.mn)  
<http://www.parliament.mn>

2018.06.20 № 30

Асуулга тавих тухай

Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгийг төлөвлөх, хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үе шат, баримтлах зарчим, оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх зорилготой Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг Улсын Их Хурлаас 2015 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр баталсан.

Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 19 тоот тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал – 2030”-ийг баталж, Монгол Улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг дундаж давхарга давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно гэсэн зорилт тавьсан.

Дээрх хууль тогтоомжуудыг хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг Монгол Улсын Их Хурлын 2015 оны 105, 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталж, хэрэгжүүлэлтийг хангахыг Засгийн газарт үүрэг болгосон.

Иймээс Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ дагуу дараахь асуулгыг Монгол Улсын Ерөнхий сайд танд хандан тавьж байна. Үүнд:

1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулж, Засгийн газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, хийсэн ажлуудын тайланг Улсын Их Хуралд ирүүлж, мэдээлэл хийх;
2. Сүүлийн 2 жилийн хугацаанд Монгол Улсын Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүд Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хуулийн дагуу хийгдсэн


эсэх, мөн "Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030"-тай хэрхэн нийцсэн эсэх талаар;

3. Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үүрэг бүхий байнгын бүтэц, тогтолцоо бий болсон эсэх, байгаа бол хаана, хэрхэн ажиллаж байгаа талаар;

Энэхүү асуулгын хариуг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



З.НАРАНТУЯА